

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2019 ОНЫ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН
ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2019 оны 12 дугаар сарын 23

Сайнцагаан сум

| Гүйцэтгэлийн зорилт арга хэмжээг хэмжих шалгуур үзүүлэлт | Тухайн жилийн хүрэх түвшин /тоо, хувь, чанар/ | Хувь |
|--|--|------|
| 1 | 2 | 3 |
| Нэг. Бүтээн байгуулалт иргэн төвтөй төрийн үйлчилгээний жилийн ажлын хүрээнд: | | |
| 1. Цэнгэлдэх хүрээлэнгийн талбайд хөнгөн атлетикийн болон хөл бөмбөгийн стандартын ногоон талбай байгуулах. | Орон нутгийн хөгжлийн сан болон улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх хөнгөн атлетикийн болон хөл бөмбөгийн стандарт ногоон талбай байгуулах ажлын тендерт “Зуут констракшн” ХХКомпани шалгарч, гэрээ байгуулан, гэрээний дагуу ажлыг эхлүүлээд байна. Үр дүн: Хөнгөн атлетикийн болон хөл бөмбөгийн стандартын ногоон талбайн ажлыг эхлүүлсэн. | 100 |
| 2. Барилгын дулаан алдалтыг тогтоож засварлах. | Байгууллагын барилгын дулаан алдалтыг аймгийн ЗДТГ-ын БХБГазрын байцаагчаар тогтоолгож, дотор хананы зарим хэсэг болон гадна талд хөөсөн фасад хийж, засварласан. Мөн аваарын шат, ус зайлуулах хоолой, барилгын эргэн тойронд бетон хаяавч цутган, байгууллагын өнгө үзэмжийг сайжруулсан. Үр дүн: Барилгын дулаан алдалтыг бүрэн засварласан. | 100 |
| 3. Байгууллагын ажилтан албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулж, иргэдийг ая тухтай үйлчлүүлэх боломжоор хангах. | Байгууллагын ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулж, иргэдийг ая тухтай үйлчлүүлэх боломж нөхцлийг бүрдүүлэхийн тулд дараах ажил үйлчилгээг хийж гүйцэтгэлээ. Үүнд: Зааланд 20 ширхэг гэрэл шинээр хийсэн. Бие засах өрөөнд агааржуулагч гаргаж, шинээр 1 ширхэг эрэгтэй суултуурыг суулгасан. Цахилгааны 2 ширхэг шийдний хайрцгийг сольсон. | 100 |

| | | |
|--|--|------------|
| | <p>Галын аюулаас урьдчилан сэргийлж, хугацаа дууссан 7 ширхэг галын хорыг цэнэглэж байрлуулсан.</p> <p>Ажлын өрөө болон зааланд 8 ширхэг дохиололын системийг байрлуулсан.</p> <p>24 ширхэг орц гарцын тэмдэг, тэмдэглэгээг хийсэн.</p> <p>Дугуйн зогсоолын талбайг бетондож, тэмдэглэгээ тавьсан.</p> <p>Барилгын эргэн тойронд бетон хаявчийг цутгасан.</p> <p>Барилгын өргөтгөлийн дээврийг засварласан.</p> <p>Байгууллагын гадна талд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж, налуу зам ба бариулыг хийсэн.</p> <p>Байгууллагын гадна хаягийг монгол бичгээр хийлгэж, гэрэлтүүлгийг сайжруулсан.</p> <p>Цонхонд хөөсөн амлагаа, усны хаялага зэргийг хийж засварласан.</p> <p>Мөн 2 өрөөнд урсгал засвар хийж, иргэд болон албан хаагчдын ая тухтай ажиллах, үйлчлүүлэх орчныг бүрдүүлээд байна.</p> <p>Үр дүн: Байгууллагын өнгө үзэмж сайжирч, албан хаагчид болон иргэдийн ая тухтай ажиллах, үйлчлүүлэх орчинг бүрдүүлсэн.</p> | |
| <p>4. Байгууллагын хашааг шинэчлэн солих, засварлах.</p> | <p>“Мандал шилтгээн” ХХКомпанитай гэрээ байгуулж, байгууллагын гадна хашааг иж бүрэн шинэчлэн сольсон. Хашаа барих гол түүхий эд болох төмрийн хэмжээсийг гэрээний гол нөхцөл болгон зааж, явцын хяналт хийж, акт үйлдэж, хашааг хүлээн авсан.</p> <p>Үр дүн: Байгууллагын аюулгүй байдлыг хангаж, өнгө үзэмжийг сайжруулсан.</p> | <p>100</p> |
| <p>5. Фитнесийн өрөөг тохижуулах.</p> | <p>Фитнесийн өрөөг өөрсдийн нөөц боломжоор тохижуулах ажлыг шат дараатай хийж байна. Фитнесийн өрөөнд толь, хэвтээ шахалтын бандан, суултын төхөөрөмж зэргийг суурилуулаад байна. Үр дүн: Иргэдийн ая тухтай үйлчлүүлэх байдал хангагдана.</p> | <p>100</p> |

| | | |
|--|---|------------|
| <p>6. Цэнгэлдэх хүрээлэнгийн халаалтын системийг хэсэгчлэн солих.</p> | <p>Цэнгэлдэх хүрээлэнгийн халаалтын системийг хэсэгчлэн солих ажлыг “Мандал шилтгээн” ХХКомпаниар хийж гүйцэтгүүлээ. Чанарын шаардлага хангахгүй болсон хагарч, задарсан 22 ширхэг паарыг сольж, халаалтын шугамын ажиллагааг хэвийн явуулж байна.</p> <p>Үр дүн: Халаалтын шугам хэвийн ажиллаж үйл ажиллагаа явуулж байгаа спорт холбоод ая тухтай сургалт явуулах боломж бүрдсэн.</p> | <p>100</p> |
| <p>8. Галын аюулаас урьдчилан сэргийлж, галын иж бүрэн хайрцаг суулгаж, өрөө тасалгаанд дохиоллын систем суулгах.</p> | <p>Спорт зааланд 2 ширхэг иж бүрэн галын хайрцаг байрлуулж, ажлын өрөө болон зааланд 8 ширхэг дохиоллын системийг шинээр суулгаж, иргэдийн болон албан хаагчдын аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.</p> <p>Үр дүн: Галын аюулын эрсдлээс эд хөрөнгө болон хүний амь нас эрсдэхээс урьдчилан сэргийлсэн.</p> | <p>100</p> |
| <p>9. Болзошгүй гамшгийн үед албан хаагчид болон иргэдийг гадагш гаргах тэмдэг, тэмдэглэгээг заал болон давхар бүрийн хананд байршуулах.</p> | <p>Болзошгүй гамшгийн үед албан хаагчид болон иргэдийг гадагш гаргах 24 ширхэг орц, гарцын тэмдэг, тэмдэглэгээг байршуулсан.</p> <p>Үр дүн: Болзошгүй гамшгийн үед аврах схемийг байршуулсан.</p> | <p>100</p> |
| <p>10. Байгууллагын гадна хашаанд мод суулгах.</p> | <p>Байгууллагын гадна хашаанд 10 ширхэг мод шинээр суулгаж, ногоон байгууламжийн өнгө, үзэмжийг сайжруулаад байна.</p> <p>Үр дүн: Ногоон талбайн өнгө, үзэмж сайжруулсан.</p> | <p>100</p> |
| <p>11. Нийт иргэдийн дунд спортын 15 төрлөөр аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах.</p> | <p>2019 онд иргэдийн дунд спортын 15 төрлөөр аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг амжилттай зохион байгуулсан. Мөн үзэгчдын дунд тухайн тэмцээнтэй холбогдолтой хөгжөөнт тоглоом тоглуулсан.</p> <p>Үр дүн: Аймгийн спортын хөгжилд ахиц гарсан.</p> | <p>100</p> |
| <p>12. Иргэдийн дунд “Дугуй унах” хөдөлгөөн өрнүүлэх “Өглөөний дасгал, алхалт, гүйлт”-ийн аян зохион байгуулах</p> | <p>“Гэгээн өглөө” сэдэвт өглөөний гүйлтийн арга хэмжээг аймгийн ахмадын хороотой хамтран сарын хугацаанд зохион байгуулж явууллаа. Тус гүйлтэнд төрийн болон төрийн бус байгууллагууд,</p> | |

| | | |
|---|--|-----|
| | <p>иргэд, ахмадууд идэвхитэй оролцож, өөрсдийн эрүүл мэнддээ үнэтэй хувь нэмэр оруулсан.</p> <p>Үр дүн: Ахмадууд, иргэд, төрийн албан хаагчдын оролцоо нэмэгдсэн.</p> <p>Аж, ахуйн нэгж байгууллага бүрийг дугуйн зогсоол хийх уриалга гаргаж, able программын олон нийтийн файлын санд байршуулсан. Дугуй спортыг сонирхож хичээллэдэг хүүхэд, залуучуудыг нэгтгэж, ойрын зайны дугуй аялалыг 10 удаа зохион байгуулж явуулсан.</p> <p>Үр дүн: Дугуй спортоор хичээллэх иргэдийн оролцоог нэмэгдүүлсэн.</p> | 90 |
| <p>13. Төрийн албан хаагчдын дунд ажлын байрны дасгал хөдөлгөөн, гимнастикийн уралдаан тэмцээнийг зохион байгуулах.</p> | <p>Аж, ахуйн нэгж байгууллагуудад ажлын байрны дасгал хөдөлгөөний видео бичлэг, зурагт хуудсыг тарааж, арга зүйгээр хангаж ажилласан. Аймгийн төвийн 8-н цэцэрлэг, Луус, Эрдэнэдалай, Дэлгэрцогт сумын төрийн албан хаагчдын дунд ажлын байрны дасгал хөдөлгөөнөөр, Сайнцагаан сумын 5-н сургуулийн ажилчдын дунд бүжиг хөдөлгөөнөөр тус бүр тэмцээнийг зохион байгуулж явуулсан.</p> <p>Үр дүн: Төрийн 13 байгууллагын 200 гаруй ажилтан албан хаагчид оролцсон.</p> | 100 |
| <p>14. Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах</p> | <p>Биеийн тамир, спортын газраас 2019-09-26-ны өдөр Чагдаржавын талбайд “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгуулсан. Өдөрлөгийн зорилго нь иргэдийг нийтийн биеийн тамир болон спортоор хичээллэх сэдэл төрүүлэх, тэдний дур сонирхлыг нэмэгдүүлэх үүднээс спортын 6 төрлөөр үзүүлэх тоглолт үзүүлж, гарын авлагыг тараасан. Тус өдөрлөгт иргэдээс сэтгэл ханамжийн судалгааг авч ажилласан.</p> <p>Үр дүн: Секц, дугуйланд хамрагдах иргэд, хүүхдийн тоо нэмэгдсэн.</p> | 100 |
| <p>15. Байгууллага, аж ахуйн нэгжүүдийн спорт хамтлагийн үйл ажиллагааг идэвхижүүлэх, арга зүйн зөвлөгөө өгөх.</p> | <p>2019 онд аймгийн хэмжээнд волейболын холбоо, Монголын хөнгөн атлетикийн холбооны дэргэдэх Дундговь аймгийн хөнгөн атлетикийн салбар холбоог тус бүр шинэчлэн байгуулсан.</p> | |

| | | |
|-------------|--|-------------|
| | <p>Сагсан бөмбөг, волейбол, таеквондо, шатар, даам, ширээний теннис, дартс, бадминтон, бөх, сур шагайн зэрэг холбоодуудтай хамтран аймгийн аварга шалгаруулах спортын 8 төрлийн тэмцээнийг зохион байгуулсан.</p> <p>Мөн “Шонхор фитнес” төв, буудлага, шатар, даам, таеквондо, сагсан бөмбөг, шагайн холбоо зэргийг Цэнгэлдэх хүрээлэнд байрлуулж, үйл ажиллагааг нь дэмжин ажиллаж байна.</p> <p>Энэ онд нийт 23 албан байгууллага, аж ахуйн нэгж спорт хамтлагийг шинээр байгуулсан. Спорт хамтлагийн тушаал болон хамтлагийн жилийн ажлын төлөвлгөөнд нь арга зүйн зөвлөгөө өгч, үйл ажиллагааг нь идэвхжүүлэн ажиллаж байна.</p> <p>Төрийн болон төрийн өмчит хувийн хэвшлийн 30 гаруй байгууллагын спорт хамтлагтай хамтран ажиллаж, бэлтгэл сургуулилтыг ханган салбарын тэмцээнд амжилттай оролцуулж байна. Мөн спорт хамтлагуудтай хамтран 10 удаагийн уралдаан тэмцээнийг зохион байгуулаад байна.</p> <p>Үр дүн: Спорт холбоо болон хамтлагтай хамтран ажилласнаар тэмцээн, уралдаанд оролцох байгууллага болон оролцогчдын тоо нэмэгдсэн.</p> | 100 |
| Нийт | | 98.3 |

ХЯНАСАН:

М.НАРАНБАДРАХ / ДАРГА/

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН:

Б.ДАШБИЛЭГ /АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН/

